

СУМАДИРАДНААГИЙН “ХАРАНХҮЙГ АРИЛГАГЧ ЗУЛ”
(MUN SEL SGRON ME, 1877) НЭРТ ТОЛЬ БИЧГИЙН ТУХАЙ

Д.Бүрнээ

Abstract

Having translated Buddhist literary work in the Tibetan language into the Mongolian language for centuries, Mongolians have enriched the Mongolian literature corpus. It is known that Tibetan-Mongolian dictionaries had been the key reference for well-known Mongolian translators. In particular, the Tibetan-Mongolian dictionary composed by Sumatiratna (Luvsanrinchen) in 1877 is noticeable. Before this dictionary, there had been published several dictionaries by Tibetan and Mongolian lexicographers in two languages, such as Tibetan-Tibetan, Tibetan-Mongolian. This article discusses how productively well-known Mongolian lexicographer Sumatiratna used not only Tibetan-Mongolian but also “Dörben jüül-ün üsüg qabsuruysan toli bičig” (18th-19th centuries) and also explanatory dictionary “Qorin nigetü tayilburi toli” (1708-1717). The original text of the dictionary “Qaranqui-yi arilyayči jula” (The Lamp Dispelling Darkness) consisting more than nine hundred pages was edited and published in two volumes in 1959, in Ulaanbaatar, Mongolia. Some features of Sumatiratna’s dictionary in terms of the macro and micro levels of its structure also was studied in this article.

Түлхүүр үг: *толь зүй, макро бүтэц, микро бүтэц, завсрын шүлэг, төгсгөлийн үг, тайлбар, орчуулга*

Буриадын нэрт эрдэмтэн, зохиолч, соён гийгүүлэгч Сумадираднаагийн намтар, бүтээлийн талаар бичиж тэмдэглэсэн зүйл цөөнгүй (Пагва, 1958; Дорж, 1962; Баяртуев, 1985; Позднеев, 1993; Бүрнээ, Энхтөр, 2006; Бүрнээ, 2002; 2004; 2010; Яхонтова, 2008; 2015; Sárközi, 2010; 2013; Sumatiratna, 2018). Т.Пагва “Монголын хэл зүйч эрдэмтэн Сумадирадна (Лувсанринчен)-гийн бүтээлүүдийн товч тойм” хэмээх өгүүлэлдээ Лувсанринченгийн бүтээлүүдээс томхон нь “Төвөд монголын дохионы бичиг нэр үг утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул оршив” (цаашид “ХАЗ” гэж товчилно) нэрт бүтээл болохыг цохон тэмдэглэснээс гадна тус толийн гар бичмэл хуудастай төвөд-монгол тайлбар толь болох тухай, Үндэсний номын санд тус толийн гар бичмэл жинхэнэ эх болон Ц.Доржийн хуулбарлан буулгасан эх гэсэн хоёр зүйлийн эх хадгалагдаж буй тухай дурджээ. Мөн Сумадираднаагийн толийн төгсгөлийн үгийн мэдээнд тулгуурлан нэрт толь зүйчийн төрсөн болон толио зохиосон оныг тодорхойлсон байна (1958: 3).

Академич Б.Ринчен Монголын Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргаж байсан Corpus Scriptorum Mongolorum цувралаар олон ховор судар номыг эрхлэн хэвлүүлсэн билээ. 1959 онд хэвлэгдсэн тус цувралын ээлжит VI, VII дугаар ботид Сумадираднаагийн толь бичгийг хэвлүүлсэн явдал бол тус толийн гар бичмэл олдохгүй байгаа өнөө үед үлэмж ач холбогдолтой ажил болсон юм. Сумадираднаагийн толь хоёр дэвтрээр хэвлэгдсэн бөгөөд эхний дэвтр 1241, удаах дэвтр 1391 хуудас, нийт 2632 хуудастай. Бид 1959 оны хэвлэлийг барьж, тус толийн зарим онцлогийг макро болон микро бүтэц талаас нь авч үзье.

Нэг. Макро бүтэц

Р.Р.К.Хартман толь бичгийн бүтцийг мега бүтэц (megastructure), макро бүтэц (macrostructure), микро бүтэц (microstructure) гэж гурав ангилжээ (Hartmann, 2001: 58). Толь бичгийн ерөнхий бүтцийг мега бүтэц гэж үзсэн бол, эхлэл, үндсэн болон төгсгөл хэсгийг макро бүтэц, толгой үгийг тодорхойлж буй бичил хэсгийг микро бүтэц гэж үзсэнтэй бид санал нэг байна. Уламжлалт төвөд-монгол толь бичгүүд оршил буюу тахилын шүлэг, толь бичгийн үндсэн хэсэг, түүнд багтах завсрын шигтгээ шүлэг, улмаар төгсгөлийн үг, тахилын шүлэг гэсэн мега бүтэцтэй.

Сумадираднаагийн толь тахилын шүлэг, завсрын болон төгсгөлийн шүлэгтэй. Нийт 70 орчим бадаг шүлгийг төвөд болон монгол хэлээр бичсэн байх бөгөөд эдгээр шүлгүүд шашин гүн ухааны утга агуулгатай бөгөөд төвөд шүлгийн тухайд үеийн тоогоор мөрийг тэнцүүлсэн, монгол шүлгийг утга дүйх үгсээр толгой холбон, айзам хэмнэлийг тааруулан найруулжээ. Төвөд цагаан толгойн гийгүүлэгч гучин үсгээр толгойлсон үгсийг жагсаахдаа тухайн үсэг тус бүрийн өмнө бурхан бодьсатва, чухаг дээд гурвын аль нэгэнд залбирсан мөргөлийн шүлгийг бичжээ. Тухайлбал, Ха (Kha) үсгээр толгойлсон үгсийн эхэнд Манзуширт, Га (Ga) үсгээр толгойлсон үгсийн өмнө лам багшид, НА (Nga)-ийн өмнө яруу найргийн охин тэнгэр Сарасватид мөргөж, залбирлын шүлэг бичжээ. Шашин, гүн ухааны утга агуулгатай шүлгээс гадна ёс зүй, ёс суртахууны холбоотой бадгууд ч байна. Тухайлбал,

Өөрт минийхийлэн тачаасныг өөрөө доор газар дар
 Өөрийг мэргэн хэмээдэг нь бусдад инээд наадны орон оо
 Өөрийг муу хэмээн санах нь бусдаас мэргэн нь тэр буй
 Өөрийг би хэмээх нь хэдэр бус адаг муу болон одьюу
 Омог ба үлэмжийн омог хийгээд
 Омгоос ч омог ба илтийн омог
 Оморхож би болой хэмээх хийгээд өчүүхэн хэмээн сэтгэх омог
 Оморхож буруудсан лугаа долоон омгоос авран соёрх

хэмээн би-д барих үзэл болон омог бардам сэтгэлийг тэвчихийг сургамжилжээ (Sumatiratna, 1959: 554-555).

Завсрын шүлгийг гийгүүлэгч гучин үсэг тус бүрээр толгойлсон үгсийн жагсаалтын төгсгөлд бичсэн байх бөгөөд ингэхдээ цагаан толгойн ямар үсгээр толгойлсон хэсэг болохоос хамаараад тухайн үгсийн дан буюу давхар үгсийн аль нэг орсон үгийг сонгон, шүлгийн мөрийг нэгэн жигд тэрхүү үсгээр найруулсан онцлогтой. Өөрөөр хэлбэл, шүлгийн хэлбэрт нийцүүлэн утга зохилдох үгсийг сонгон оруулж, уран яруу шүлэглэжээ.

Толь бичгийн макро бүтцэд төгсгөлийн үг зайлшгүй холбогдоно. Төгсгөлийн үгд зохиогчийн толио зохиох болсон учир шалтгаан, хэрхэн найруулсан болон бичсэн оныг тодорхой дурджээ. Төгсгөлийн үгийн мэдээнээс үзвэл Сумадираднаа толио 1877 онд 57 настайдаа найруулжээ. Мөн тэр бээр тухайн үед сургуулийн яамны туслагч түшмэлийн албыг хашиж байсан байна. Өмнө гарсан толь бичгүүд хураангуй байсныг Сумадираднаа тэмдэглэж, олон зүйл толийг ашиглаж, судрын буюу бичгийн хэлний төдийгүй ярианы хэлний үгийг ч оруулан, дэлгэрүүлж найруулсан тухайгаа дурджээ.

Сумадираднаагийн бичсэн энэхүү төгсгөлийн үгээс гадна 1959 оны хэвлэлийн төгсгөлийн үгийг авч үзье. Тус хэвлэлийн оршлыг Б.Ринчен франц хэлээр бичихдээ Сумадираднаагийн толийн анхны эхийн талаар мэдээлсэнгүй. Тиймээс тус толийн төвөд хэлээр бичсэн төгсгөлийн үгээс толь бичгийн анхны эхийн талаар таамаглах боломжтой байгаа юм. Үүнд, юуны өмнө тус толийн зарим орчуулга дутуу байсныг бид мэдэж авч байна. Б.Ринчен, Гандантэгчинлин хийдийн цогчин гэсгүй Гомбодорж нар эрхэлж, орчуулгагүй хэсгийг МУИС-ийн төвөд хэлний багш гавж Дорж, Гандан хийдийн гавж Гомбожав, гэвш Дугар, гавж Очир, гавж Данзан-Осор, гэвш Лхамжав, гэвш Данигаа буюу Дамдинсүрэн, гэвш Иштавхай, гэвш Аюуш, манба

Ядамсүрэн, зурхайч Доржжалцан, гэвш Чогжав, Батсүх нар нөхөн гүйцэтгэсэн болохыг тус төгсгөлийн үгд тэмдэглэжээ. Эдгээр эрдэмтэн лам нарын орчуулга хийхдээ ашигласан тэжээх ухаан, одон зурхай, зохист аялгуу, дуун ухаан, шинэ хуучин дохионы шастир, түүвэр үгсийн толь тэргүүтнийг төгсгөлийн үгд дурдахын хамт сийрүүлэн бичсэн гавж Базаррагчаа, Дагвадорж, Лувсандорж, Одсэр, Барс, Жамсринжав нарын нэрийг бас тэмдэглэжээ. Энэхүү мэдээнээс үзвэл Сумадираднаагийн толь бичгийн зарим үг хэллэгийн төвөд тайлбарын орчуулга дутуу байсныг Гандан хийдийн лам нар болон МУИС-ийн багш нар хамтран нөхөн гүйцээж орчуулжээ. Орчуулгыг хийж гүйцэтгэхэд төрөл бүрийн эрдэм ухааны салбарыг төлөөлсөн багш, маарамба, зурхайч, зохист аялгууч, буддын гүн ухаанд мэргэшсэн хүмүүс оролцсон байна.

Төвөд-монгол толь бичгийн түүхийг сөхвөл монголчууд олон арван толь бичиг зохиож иржээ. Бидэнд мэдэгдэж буй хамгийн эртний төвөд-монгол толь бол 1718 онд хэвлэгдсэн Брова равжамба Гунгаажамцын “Нарны гэрэл” (Nyí ma’i ‘od) болон “Их наран” (Nyí ma chen po) толь юм. Тус толиос гадна монголчуудын дунд нэрд гарсан толь бичгүүд бол 1737 онд Гүн Гомбожав нарын зохиосон “Төвөд үг хялбар сурах” (rTogs par sla ba), Жанжаа хутагт Ролбийдорж нарын 1742 оны “Мэргэд гарахын орон” (mKhas pai ‘byung gnas), Агваандандар лхаарамбын 1838 онд хэвлэгдсэн “Сарны гэрэл” (zLa ba’i ‘od), Гирдибазарын “Нэр, үг, утга гурвыг тодотгогч” (Ming tshig don gsum gsal byed) (19 дүгээр зуун), Төгөлдөрийн Галсанжамбын “Нэр, утгыг гийгүүлэгч зул” (Ming tshig gsal byed sgron me) (1872) тэргүүтэн толь болно. Эдгээрээс гадна монголчуудын дунд төвөд мэргэдийн зохиосон “Самадог” (16 дугаар зуун), “Агдон” (1538), “Лиш гүрхан” (1536), “Мражан” (15 дугаар зуун) тэргүүтэй толь бичгүүд их алдартай (Burnee, 2021). Сумадираднаа толь бичгээ найруулахдаа шашин номын хүрээний эдгээр толь бичгээс гадна төр иргэний чиглэлийн толь болох “Дөрвөн зүйлийн үсэг хавсарсан толь бичиг” буюу “Манж-монгол-төвөд-хятад дөрвөн хэлний толь” (18-19 дүгээр зуун) (цаашид “Дөрвөн хэлний толь” гэж товчилно) болон “Хорин нэгт тайлбар толь” (1708-1717) тэргүүтнийг ашиглажээ.

Хоёр. Микро бүтэц

Толь бичгийн микро бүтцэд толгой үгийг хэрхэн тодорхойлж буй хэсэг багтана. Үүнд, толгой үгийн хэлний зүй, үгсийн сан, утга зүйн холбоотой тодорхойлолт холбогдоно. Орчин цагийн толь бичигт толгой үгийг зүүн гар талд байрлуулж, баруун талд тухайн үгийн холбоотой мэдээллийг оруулдаг. Уламжлалт төвөд-монгол тольд толгой үгийг судрын хэлбэрт тааруулж, ар араас нь хөндлөнгөөр нь жагсааж, орчуулгыг толгой үг тус бүрийн доор бичнэ. Ингэхдээ тухайн үгсийн жагсаалтын төгсгөлд цагаан толгойн ямар үсгээр толгойлсон болохыг дурдаж, төгсгөлийн шүлгийг төвөд, монгол хоёр хэлээр бичдэг уламжлал байжээ. Энэ уламжлалыг Сумадираднаа чанд мөрдсөн байна.

“ХАЗ”-д өмнөх толь бичгүүдэд ямар нэгэн хэмжээгээр үгийн дараалал тэр бүр мөрдөгдөж чадаагүйг цэгцэлж, толгой үгсийг цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулах журмыг илүү мөрдөж чаджээ.

Уламжлалт төвөд-монгол толь бичгийн толгой үгд үг, холбоо үг, өгүүлбэр ч орсон байх бөгөөд тухайн толгой үгийн салаа утгын тоогоор толгой үгийг давтан тэмдэглэж байв. Брова равжамбын “Нарны гэрэл” (1718) толь үүний нэг тод жишээ юм. Тус тольд толгой үгийн салаа утгыг бичихдээ утгын тоогоор төвөд толгой үгийг 2-7 хүртэл удаа давтан бичжээ. “Нарны гэрэл”-ээс хойно гарсан толь бичгүүдэд салаа утгын орчуулгыг нэг толгой үгийн доор багтааж бичих хандлага бий болсон байна.

Үг хэллэгийг тайлбарлах төвөд толь бичгийн уламжлал байжээ. Тухайлбал, төвөд бичгийн хэлний нэртэй толь бичгүүд болох “Самадог”, “Агдон”, “Лиш гүрхан” тэргүүтэнд үг хэллэгийг тайлбарласан жишээ цөөнгүй. Брова равжамбын “Нарны гэрэл”-д толгой үгийн тайлбар цөөн байх ба тайлбарыг төвөд, монголоор бичжээ. Сумадираднаагийн толийн тайлбар

өмнөх толь бичгүүдийн тайлбартай холбоотой. Нэн ялангуяа Гирдибазарын тайлбартай ихээхэн холбоотой байгаа нь бидний анхаарлыг татсан юм. Гирдибазарын “Нэр, үг, утга гурвыг тодотгогч” (цаашид НҮУГТ гэж товчилно) тольд зохиосон он цагийг дурдаагүй боловч Сумадираднаагийн толиос өмнө гарсан болохыг тус толийн төгсгөлийн үгээс мэдэж болно. Гирдибазарын ашигласан сурвалж бичиг болон толь бичгийн дотор Агваандандарын толийг дурджээ. Агваандандарын “Сарны гэрэл” (1838) төвөд- монгол дохионы толь бичгээр баримжаалбал Гирдибазарын толь 1838 оноос хойно гарчээ. Гирдибазарын тольд өмнө гарсан толиудтай харьцуулахад тайлбар олон байх бөгөөд төвөд тайлбарыг орчуулалгүй авсан байна. Сумадираднаа Гирдибазарын тайлбарыг мөн орчуулахгүй авсныг 1959 онд тус толийг хэвлэх үед нөхөн орчуулсан бололтой. Дурдсан хоёр толийн холбоог харуулах жишээг авч үзье.

№	Гирдибазарын толь “НҮУГТ”	Сумадираднаагийн толь “ХАЗ”	Тэмдэглэл
1	Ko tam pa'i ras- ras bal gyi rgyu dang srin bal gyi spun byas nas btags pa'i ras	<u>kotambakam</u> Ko tam pa'i ras- ras bal gyi rgyu dang srin bal gyi spun byas nas btags pa'i ras Хөвөнгийн голт ширхэг ба ёнхорын хөндлөн ширхэг хийж нэхсэн бөс	Гирдибазарын тольд толгой үг болон тайлбарыг орчуулсангүй. Сумадираднаагийн тольд энэхүү санскрит гаралтай толгой үгийг төвөд үсгээр галиглаж, тайлбарыг орчуулжээ.
2	Dong ga ni drod che sar gzhan la 'khril nas skye ba lo ma dang me tog che zhing ro mngar la cung zad tsha ba khrag gis brkyangs pa'i rgyu ma 'dra ba'i thog gu can zhig ste <u>'di ni</u> me tog ser por bshad do	Dong ga ni drod che sar gzhan la 'khril nas skye ba lo ma dang me tog che zhing ro mngar la cung zad tsha ba khrag gis brkyangs pa'i rgyu ma 'dra ba'i thog gu can zhig ste <u>'di'i</u> me tog ser por bshad do Донга нь их дулаан газарт бусдыг ороож ургах навч ба цэцэг их бөгөөд амттай бөгөөд өчүүхэн халуун цусаар тэлсэн гэдэс мэт үрт нэгэн бөгөөд үүний цэцэг нь шар хэмээн номловай.	Хоёр толь <u>'di ni</u> (энэ нь) гэснийг <u>'di'i</u> (үүний) гэж найруулсан төдий ялгаатай. “ХАЗ”-д тайлбарыг орчуулжээ.

Дээрх жишээнээс харвал Сумадираднаа бээр Гирдибазарын толийг ашигласан нь тодорхой харагдах бөгөөд ийм жишээ цөөнгүй бий. Өөрөөр хэлбэл, “ХАЗ” толь бичгийн зарим орчуулгагүй байсан хэсгийг бид юу гэж тайлбарлаж болох вэ гэвэл Сумадираднаа толио дутуу хийсэн хэрэг бус, харин уламжлалыг дагаж, төвөд тайлбарыг орчуулахгүй авсантай холбоотой гэж үзэж байна. Сумадираднаагийн тайлбараа хийхдээ ашигласан өөр нэг толь бол Агваандандарын “Саруул оюутны хүзүүний чимэг” (blo gsal mgrin rgyan) толь юм. Тус толь бол хуучирсан үг хэллэгийг тайлбарласан төвөд-төвөд толь бөгөөд энэ тольд тайлбарыг ямар эх сурвалжаас авснаа Агваандандар тэмдэглэсэн байна (Бүрнээ, 2020: 109-114). Гирдибазар болон Сумадираднаа нар Агваандандарын тайлбарыг аль аль нь авчээ. Ингэхдээ Сумадираднаа Гирдибазарыг дагаж тайлбарыг хуулсангүй, харин найруулан засчээ. Тухайлбал, skyin gor гэсэн үгийг Агваандандар бээр “srog chags khung nga gnas pa dang da byid yin shes bshad pa yod kyang las chog nram rgyal gser mdog las sram yin par bshad do” гэснийг Сумадираднаа авахдаа “srog chags khung nga gnas pa dang” гэсэн хэсгийг хасаад, оронд нь Жогдон Ринчендашийн “Лиш гүрхан” (1536) толиос “skyin gor ni gangs sbal lam rstangs pa” гэсэн хэсгийг авч, Агваандандарын толиос “da byid yin shes bshad pa yod kyang las chog nram rgyal gser mdog las sram yin par bshad do” гэсэн хэсгийг залган бичиж найруулжээ.

Сумадираднаа өмнөх үеийн толь зүйчдийн төвөд- төвөд, төвөд- монгол толь зохиох арга зүйг бүтээлчээр ашиглахын сацуу манж- монгол толь бичиг зохиох арга зарчмыг бас судалжээ (Бүрнээ, 2002; 2010). Тухайлбал, төр иргэний номын зүйл хуваасан “Дөрвөн хэлний толь”-оос

төвөд, монгол үгсийг сугалан авч, монгол тайлбарыг “Хорин нэгт тайлбар толь”-оос (1708-1717) сийрүүлэн бичиж найруулсан нь эдүгээ гар нооргоор ОХУ-ын Санкт Петербургийн их сургуулийн Дорно дахины факультетын номын санд хадгалагдаж байна. Тус гар бичмэл “Цуулгын дацангийн ширээт ба сургуулийн багш Номтын олон зүйл толь бичгүүдийг үзэж, аль олдсон тайлбар нэмрийн ёсоор хавсаргасан төвөд монгол хэлний толь бичиг оршив” гэсэн нэртэй, орос цаасан дээр бичсэн найман дэвтрээс бүрдэнэ (Бүрнээ, 2002:61). Сумадираднаа энэхүү гар бичмэлээ “ХАЗ”-толио найруулахдаа ашигласан байх бөгөөд эдгээр монгол тайлбарыг ажиглавал ихэнхдээ монголын аж байдал, иргэний соёлтой холбоотой үг хэллэг зонхилж, бурхан шашны үгс ховор байна. Харин төвөд-төвөд тайлбарт шашин номын үг хэллэг зонхилно (Бүрнээ, 2002: 78-79). Тухайлбал *skyabs su mchi* буюу авралд орсугай хэмээх хэллэгийг тайлахдаа эхлээд *skyabs* буюу аврал, дараа нь *chi* буюу орох хэмээх үгсийг дэлгэрэнгүй тайлж, тус хэллэг нь “гурван эрдэнийг шүтээн болгон барьж өөрийн оюуныг түүний зүгт явуулах ба одуулах бөгөөд гурван эрдэнэд өр гол зүрхээ нотлон даалгах” гэсэн утгатай гээд улмаар бурханд итгэмүй, номд итгэмүй, хуврагт итгэмүй хэмээх хэллэгүүдийг залган бичиж тайлбарлажээ. “ХАЗ”-д шашин гүн ухааны нэр томьёоноос гадна гэжээх ухаан, дуун ухаан, урлахуй ухаан, одон зурхай зэрэг эрдэм ухааны холбоотой нэр томьёо арвин тааралдана. Түүнчлэн ургамал, амьтны аймгийн холбоотой нэр томьёо ч олон байгаа бөгөөд санскрит гаралтай нэр томьёог төвөд үсгээр галиглаж, тайлбарлажээ. Аман зохиолын нэг хэлбэр болох зүйр цэцэн үгийн тайлбар ч тааралдана. Тухайлбал, энд *dkar na zho dmar na krag* гэсэн хэллэгийг хэрхэн орчуулж тайлбарласныг авч үзье. Тус хэллэгийг “цагаан болбоос тараг улаан болбоос цус” гэж орчуулаад “сайн болбоос сайныг шийдэх ба муу болбоос мууг шийдэн үйлдсү хэмээн хатуу зоригт нэгэн хэрэгтэйн утга болой. Утгыг хурааваас анхааран авагч хойш тавьж суух хийгээд оюунаа үл зүглүүлэх хөшүүн ба шамдан хичээхгүй сул сууж үл болох бөгөөд сайн муу алин мөн болов туйлд хүрэх хэрэгтэй хэмээн үнэн зүрхнээс хичээх нэгэн хэрэгтэй хэмээхийн утга мөн болох хэмээн санавай” гэж тайлбарлажээ (Бүрнээ 2002: 76). Толгой үгийн тайлбар товч хураангуй байхаас гадна хэдэн хуудас дамнасан дэлгэрэнгүй тайлбар ч бий.

Хэлний зүйн зарим онцлогийн тухайд төвөд хэлний үйл үгийн одоо, өнгөрсөн, ирээдүй цаг төдийгүй монгол хэлний үйл үгийн хэв, байдлын нөхцөлтэй дүйх хэлбэрийг бас толгой үгд оруулжээ. Сумадираднаагаас өмнөх үеийн толь зүйчид төвөд хэлний үйлдэгч (*byed pa'i gnam dbye*), Ла-гийн утгат тийн ялгалын (*la don gyi gnam dbye*) сул үгээр хэлбэржсэн нэр үгийг толгой үгд оруулж байсан бол Сумадираднаа нэрлэхийн тийн ялгал бүхий нэр үгийг толгой үгд авсан нь бас нэг ололт юм.

Орчуулгын тухайд ойролцоо үгээр хөрвүүлэхийг чухалчилсан байна. Тухайлбал, *dkar gsal*- цонх, цонж, өрх; *bkri ba*- хураах, эвхэх, ороох; *bkrag*- хурц, дурдмал, тунгалаг; *kar ma ra*- гармачин, гарматан, гармын ёс баригчин; *'bul nor*- өгцөө, барьц, өргөлөг, өргөл, өргөц; *bem ro*- минчүүрэх, мэнэрэх, бадайрах, мэдээгүй болох; *'rhyap*- бэдэх, тэнүүчлэх, хэсэх, төөрөх гэх мэт. “ХАЗ”-д илт өгүүлэх нэр буюу ёгт нэр арвин бий. Тэдгээрийг өмнөх толь зүйчид зарим нь орчуулалгүй зөвхөн юуны нэр болохыг тэмдэглэсэн (Гунгаажамц, Агваандандар) бол Сумадираднаа өмнөх толь зүйчид болох Гүн Гомбожав нарын нэгэн адил орчуулахын сацуу юуны нэр болохыг нь ч бас давхар тэмдэглэжээ. Энэ нь төвөд хэл суралцагчдад тухайн үгийн утгыг ухан ойлгож, хэрхэн ёгтолж буйг мэдэж авах, орчуулах арга барилд суралцахад тустай юм. Тухайлбал: *mig gi gnyen*- нүдний садан (гогод эм, хөх удвал), *mig gis thos pa*- нүдээр сонсогч (могой), *mig gi nor bu'i khyim*- нүдний чандманийн гэр (сормуус), *mig brgyad pa*- найман нүдэт (Эсэрваа тэнгэр), *mig sngon*- хөх нүдэт (ууль) гэх мэт. Эдгээр жишээнээс бид “нүд” хэмээх үг орсон эдгээр ёгт нэр чухам юуны нэр болох ба Сумадираднаа хэрхэн орчуулсныг харж байна.

Толь бичгийн төрөл зүйлийн тухайд “ХАЗ” бол үсэг дараалуулсан, төвөд- монгол хэлний орчуулгын толь юм. Тус толийг “даяг” буюу “дохионы бичиг” (*brda yig*) гэж нэрлэсэн байх бөгөөд ийм нэрийг анх түрүүн гүн Гомбожав “Хялбар сурах” (*rtogs par sla ba*) (1737)

толь бичигтээ өгснөөс хойш Агваандандар, Гирдибазар, Галсанжамба, Сумадираднаа нар уламжлан авчээ. Өмнөх дохионы бичгүүд “нэр, утгыг тодотгогч” буюу “нэр утгыг гийгүүлэгч” нэртэй байсан бол Гирдибазар болон Сумадираднаа нар “нэр, үг, утга гурвыг тодотгогч” буюу “гийгүүлэгч” гэж толио нэрлэжээ. Бичгийн хэлний уламжлалт “нэр” (ming) хэмээх ухагдахуун бол үгтэй, “үг” (tshig) бол холбоо үг, хэллэгтэй дүйх ойлголт юм.

Сумадираднаа бээр үг, хэллэгийг тайлбарлахын тулд уламжлалт толь бичгүүдийг шүүн нягталж, оновчтой гэж үзсэн хэсгийг сонгон авч найруулах төдийгүй, сурвалж бичгүүдээс холбогдох тайлбар тэргүүтнийг авч засан найруулж, бүтээлчээр боловсруулсан байна. Тиймээс бид Рона-Таш (Sumatiratna 2018: V), В.Симон (Simon 1964:99) нарын зарим судлаачид уг толийг төвөд-төвөд толь байсан бөгөөд хожим нь Сумадираднаа зөвхөн монгол орчуулга хадсан гэж үзсэнтэй санал нийлэхгүй байна.

Дүгнэлт

Сумадираднаагийн толь өмнөх үеийн толь зүйчид болох Брова равжамба Гунгаажамц, гүн Гомбожав, Агваандандар, Гирдибазар болон төвөд толь зүйчдийн бүтээлтэй салшгүй холбоотой. Тэр бээр өмнөх толь зүйчдийн арга барилыг судалж, ололттой зүйлийг уламжлан авч хөгжүүлжээ. Өмнөх үеийн толь зүйчдийн боловсруулсан тольд шашин номын үг хэллэг зонхилж, иргэний соёлын холбоотой үг хэллэг харьцангуй цөөн байсан бол Сумадираднаа “Дөрвөн хэлний толь”, “Хорин нэгт тайлбар толь” тэргүүтнийг бүтээлчээр ашиглан, зарим тайлбарыг товчлон хураангуйлж, заримыг хэвээр авч, заримыг засан найруулж, төр иргэний болон шашин номын үг хэллэг аль алиныг багтаасан, өмнөх үеийн толь бичгээс илүү олон үгтэй, өргөн хэрэглээний толь бичиг найруулж чаджээ. Тус толийн доторх зарим төвөд тайлбарын орчуулга дутуу байсныг 1959 оны хэвлэлийг бэлтгэхдээ нөхөн оруулсан нь өнөө цагийн монгол, төвөд хэл, утга зохиолыг судлаачдын эрэлт хэрэгцээнд улам бүр нийцсээр байна.

Ном зүй

- Burnee D.** 2021. *“Easy to Learn” (rTogs par sla ba) (1737) as a source for the study of Tibetan-Mongolian lexicographic relations.* Études
- Hartmann R.R.K.** 2001. *Teaching and Researching Lexicography.* Routledge. 224 p.
- Redigit prof. Dr. Rintchen.** Нэгдүгээр дэвтэр 1241х., хоёрдугаар дэвтэр 1391х.
- Sárközi A.** 2010. *Translating the Buddhist Scriptures.* Proceedings of the Conference held in November 24–25, 2008 in Budapest (Eötvös Loránd University, Department of Inner Asian Studies: Budapest), pp. 101–109.
- Sárközi A.** 2013. *The dictionary of Sumatiradna.* 53rd Annual Meeting of the Permanent International Altaistic Conference, Institute of Oriental Manuscripts, RAS St.Petersburg, July 25-30, 2010, Studien zur Sprache, Geschichte und Kultur der Türkvolker, Band 13, Klaus Schwarz Verlag Berlin, pp. 364-370.
- Simon W.** 1964. *Tibetan lexicography and etymological research, Transactions of the Philological Society.* pp. 85-107.
- Sumatiratna.** 1959. *Bod hor kyi brda yig ming tshig don gsum gsal bar byed pa'i mun sel sgron me/ Tübed mongyol-un doqiyau-u bičig ner-e üge udqa yurban-i todurayulun qarangu-i arilyaüci jula.* Улаанбаатар. Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэр.
- Sumatiratna.** 2018. *Tibetan-Mongolian Explanatory Dictionary with English Equivalents and Index of Mongolian words, edited by Alice Sárközi.* Admon printing. 1900 x.
- Баяртуев Б.Д.** 1985. *Жизнь и творчество Ринчена Номтоева (1820-1907).* В кн.: Буддизм и литературно-художественное творчество народов Центральной Азии, Новосибирск, с. 78-84.
- Бүрнээ Д.** 2002. *Сумадираднаагийн тольд нэрийг тайлсан тухай.* Acta Mongolica, МУИС-ийн ЭШБ, Vol.1 (182), х. 073-083. Улаанбаатар.
- Бүрнээ Д.** 2004. *Сумадираднаа ба Перихийн толь бичгүүдийг харьцуулах нь.* Mongolica, An international Annual of Mongol Studies VOL.14 (35), pp. 79–90. UB.
- Бүрнээ Д.** 2010. *Сумадираднаагийн нэгэн гар бичмэлийн тухай.* Acta Mongolica, volume 10 (342), х. 61-64.
- Бүрнээ Д.** 2020. *“Саруул оюутны хүзүүний чимэг” толь бичгийн онцлог.* МУИС, Эрдэм шинжилгээний бичиг. Боть XLIV (543). х. 109-114. Улаанбаатар.
- Бүрнээ Д., Энхтөр Д.** 2006. *Төвөд-монгол толь бичиг.* Адмон хэвлэлийн газар. Улаанбаатар. 533 х.
- Дорж Ц.** 1962. *Töbed-Mongyol dokiyan-u bičig tegüber neres-ün jüil.* Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал. ред. Ц.Дамдинсүрэн. х. 86-115.
- Пагва Т.** 1958. *Монголын хэлзүйч эрдэмтэн Сумадирадна (Лувсанринчен)-гийн бүтээлүүдийн товч тойм.* Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл. Улаанбаатар. 14х.
- Позднеев А.М.** 1993. *Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства.* Элиста. 492 с.
- Яхонтова Н.С.** 2008. *Именования Солнца в тибетско-монгольском словаре Суматиратны (XIX век) // Буддийская культура: история, источниковедение, языкознание и искусство. Вторые Дорджиевские чтения. Материалы конференции Санкт-Петербург: 9-11 ноября 2006 г. Санкт-Петербург. 2008. с. 339-359.*